



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ЧАНАР, ХЭРЭГЖИЛТ,  
ҮР ӨГӨӨЖИЙГ БИЙ БОЛГОХ НЬ

ИЛТГЭЛ БИЧСЭН:  
АХЛАХ АУДИТОР Ц.ОТГОНБАЯР  
АУДИТОР Т.ОДСҮРЭН

2023.06.20

## УДИРТГАЛ

**Сэдвийн зорилго:** Төрийн аудитын шийдвэр нь төрийн удирдлагын ил тод, хариуцлагатай байдал, үр дүнтэй засаглалыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд шийдвэрийн чанар нь төрийн байгууллагуудын санхүүгийн удирдлага, гүйцэтгэлд шууд нөлөөлдөг. Энэхүү илтгэл нь төрийн аудитын шийдвэрийн чанарт дүн шинжилгээ хийж, тэдгээрийн ач холбогдол, чанарт нөлөөлж буй гол хүчин зүйлс, тулгарч буй бэрхшээл, сайжруулах боломжит чиглэлүүдийг тодруулах зорилготой юм.

**Судлагдсан байдал:** Монгол Улсад Төрийн аудитын тогтолцоо, төрийн аудитыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн аудитыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг 2003 онд анх хуульчилснаас хойш өдгөө 20 жилийн түүхэн замналыг ардаа үлдээсэн байна.

Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтлан ажиллах эрх зүйн үндсийг 2020 оны Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөлт оруулсан байна.

Үүнтэй холбоотойгоор төрийн аудитын байгууллага нь олон улсын стандартын дагуу аудитын чанарыг баталгаажуулах, хяналттай холбоотой ISSAI-ийн заалтуудыг хэрэгжүүлж байна.

Төрийн аудитын байгууллага нь хуульд заасны дагуу үйл ажиллагаандаа төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтлан ажилладаг.

АДБОУБ-аас 2019 онд АДБОУС-ыг шинэчилсэнтэй уялдуулан Төрийн аудитын MNS 6817:2020 стандартыг батлуулан дагаж, мөрдөж байна. Төрийн аудитын байгууллагаас 2022 онд аудитын чанарын хяналтын журмын хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг хийж МУЕА-ын 2023 оны А/20 дугаар тушаалаар “Аудитын чанарын хяналтын журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Гэвч аудитын ажлын шийдвэрийн чанар, хэрэгжилт, үр өгөөжийг бий болгоход олон хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд тэдгээрийг тодорхойлох, ангилах, хүчин зүйлийн нөлөөллийг тооцох оролдлогыг дэлхийн улс орнуудад олон эрдэмтэн судалгааны ажил хийж ирсэн боловч Монгол улсын хувьд энэ асуудлаар хийсэн дорвитой судалгааны ажил байхгүй байна.

Тиймээс энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэж, бага ч болов Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын шийдвэрийн чанар, хэрэгжилт, үр өгөөжийг бий болгоход нөлөөлөх хүчин зүйлсийг харьцуулалт хийж, үр дүн гаргахыг зорьсон ба аудитын шийдвэрийн чанарт нөлөөлдөг гол хүчин зүйлийн талаар нэгдсэн ойлголтой болох зэрэг ач холбогдолтой юм.

**Судалгааны арга зүй:** Судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилтоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг ярилцлага хийх, онол, практикийг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, судалгаа тооцооллыг үндэслэх зэрэг арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, судалгааны үр дүнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлно.

**Судалгааны эх сурвалж:** Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад эрдэмтэн, судлаачдын бүтээл, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тухайн чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүн зэрэг нь эх сурвалж болно.

### **Төрийн аудитын шийдвэрийн ач холбогдол:**

Төрийн аудитын шийдвэр нь хариуцлагыг дээшлүүлэх, залилан мэхлэх, үрэлгэн зарцуулах, төсвийн хөрөнгийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. Эдгээр нь санхүүгийн тайлан, дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн үйл ажиллагааны үр ашигт бие даасан үнэлгээ өгдөг. Аудитын шийдвэрийн чанар нь олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, засаглалын үйл ажиллагааг сайжруулах, дутагдлыг арилгахад чиглэсэн залруулах арга хэмжээг удирдан чиглүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

### **Төрийн аудитын шийдвэрийн чанар**

Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын шийдвэрийн чанар нь төрийн захиргааны ил тод байдал, хариуцлагатай байдал, үр дүнтэй засаглалыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, ур чадвар, стандартыг дагаж мөрдөх, хангалттай нөөц, цаг тухайд нь тайлагнах зэрэг нь аудитын шийдвэрийн чанарт нөлөөлдөг гол хүчин зүйлүүд юм.

Гэсэн хэдий ч улс төрийн хөндлөнгийн оролцоо, нөөцийн хязгаарлалт, төрийн удирдлагын ээдрээтэй холбоотой бэрхшээлүүд байсаар байна. Үүнээс гадна Төрийн

аудитын шийдвэрийн чанарт сөргөөр нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйл байна. Эдгээр хүчин зүйлүүд нь аудиторын хязгаарлалт, байгууллагын хязгаарлалт, гаднын нөлөөлөл зэрэг янз бүрийн эх сурвалжаас үүдэлтэй байна.

Төрийн аудитын шийдвэрийн чанарт нөлөөлж болох нийтлэг хүчин зүйлсийг энд дурдъя.

- *Мэргэжлийн үр чадвар хангалтгүй*: Хэрэв аудиторууд тодорхой чиглэлээр шаардлагатай үр чадвар, мэдлэг, туршлага дутмаг байвал энэ нь аудитын явцад алдаа гаргах, орхигдуулах, дутуу үнэлгээ өгөхөд хүргэдэг. Энэ нь эцсийн аудитын шийдвэрийн чанарыг алдагдуулж болзошгүй.
- *Хязгаарлалт ба хараат бус байдлын асуудал*: Аудиторууд аудитын үйл явцын туршид хараат бус байдал, бодитой байдлыг хадгалах ёстой. Гэсэн хэдий ч ашиг сонирхлын зөрчил, хувийн харилцаа, удирдлага болон бусад сонирхогч талуудын зүй бус нөлөөлөл зэрэг хүчин зүйлүүд нь нэг талыг барьсан эсвэл алдагдуулсан аудитын шийдвэр гаргахад хүргэдэг.
- *Аудитын үр ашиггүй төлөвлөлт*: Буруу боловсруулсан аудитын төлөвлөгөө нь аудитын горимыг орхигдуулсан эсвэл хангалтгүй болгож, аудитын дүгнэлтийг дутуу эсвэл буруу гаргахад хүргэдэг. Тохиромжгүй төлөвлөлт нь өндөр эрсдэлтэй газрууд эсвэл аудитын гол тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход саад болно.
- *Нөөц ба цаг хугацааны хязгаарлалт*: Чанартай аудит хийхэд цаг хугацаа, төсөв, боловсон хүчин зэрэг хангалттай нөөц зайлшгүй шаардлагатай. Хангалтгүй нөөц нь яаран аудит хийх, хангалтгүй туршилт хийх, шийдвэр гаргахад саад учруулдаг.
- *Технологийн дэвшил*: Технологийн дэвшил нь төрийн аудитын шийдвэрийн чанарт эерэг болон сөргөөр нөлөөлдөг. Аудитын дэвшилтэт хэрэгслүүд болон өгөгдлийн аналитик нь аудитын үр нөлөөг сайжруулж болох ч аудиторууд технологийг үр дүнтэй ашиглахад дасан зохицож, шаардлагатай үр чадварыг эзэмших хэрэгтэй.

Иймд Төрийн аудитын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, төсөв санхүү, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх, оролцогч талуудын оролцоог дэмжих, технологийн дэвшлийг ашиглах замаар төрийн аудитын шийдвэрийн чанар, үр нөлөөг сайжруулж, төсвийн хөрөнгийн оновчтой зарцуулалтыг баталгаажуулж, засаглалын үйл явцад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх боломжтой.

Аудитын дээд байгууллага ИНТОСАИ-аас хийсэн судалгааны үр дүнгээр аудитын өндөр чанартай шийдвэр гаргахад аудиторын хараат бус байдал, аудиторууд хууль бус

нөлөөллөөс ангид байх үед гаргасан шийдвэр нь **илүү найдвартай, үнэмшилтэй** байдаг нь батлагдсан байна.

Аудитын шийдвэрийн чанар, хэрэгжилтийг Дорнод болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн жишээ дээр авч үзье.Үүнд:

Дорнод аймаг дахь ТАГ-ын 2021-2023 онд хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дараах дүгнэлтүүдийг 2-3 удаа буюу жил бүр дараалан өгсөн боловч шийдвэрлэгдээгүй байна.

- “Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна” гэсэн дүгнэлтийг 3 жил дараалан,
- “Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.” гэсэн дүгнэлтийг 2 жил дараалан,
- “Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй” гэсэн зөрчилд 3 жил дараалан зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй тул 2021 оны аудитаар албан шаардлага өгсөн байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэж аудитын шийдвэр гарах ёстой боловч Дорнод аймаг дахь ТАГ-ын тайланд ямар зөрчилд өгсөн албан шаардлага, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлыг тодорхой дурдаагүй байна. Өөрөөр хэлбэл тайлангийн хэрэглэгчид аудитын зөрчлийн шийдвэрлэлтийг ойлгомжтой байдлаар тайлагнаагүй байна.

Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын 2021-2023 онд хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дараах дүгнэлтүүдийг буюу жил бүр дараалан өгсөн боловч шийдвэрлэгдээгүй байна.

- “Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.” гэсэн дүгнэлтийг 3 жил дараалан өгч, албан шаардлага хүргүүлсэн,
- “Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг бус машин, тоног төхөөрөмж худалдан авах

*төсөл арга хэмжээг түлхүү байдлаар тусгаж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.” гэсэн дүгнэлтийг 3 жил дараалан өгч, зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн,*

- *“Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үр дүнг үнэлээгүй байна.” гэсэн дүгнэлтийг 3 жил дараалан өгч, зөвлөмж хүргүүлсэн байна.*

Дээрх зөрчлийг арилгахын тулд аудитын байгууллагууд нь “Орон нутгийн төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөх” аудитыг хийж гүйцэтгэхдээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хасах санал оруулдаг боловч хэвээр баталдаг, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдөд төсөв батлахтай холбоотой сургалт хийж тодорхой ойлголттой болгодог боловч ихэнх төлөөлөгчид нь дараагийн сонгуулиар солигддогтой холбоотой байна. Тухайлбал: Сэлэнгэ аймгийн 2012, 2016, 2020 оны сонгуульд ИТХ-ын төлөөлөгчдийн 20 хувь нь 2-3 удаа сонгогдсон бол 80 хувь нь солигдсон байна.

Мөн төрийн албан хаагчийн цалин бага, томилгоо нь улс төрийн намуудаас хараат байдгаас аймаг, сумдын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн их солигдож, аудитын шийдвэр бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэж байна. Тодруулбал аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн сүүлийн 4 жилд 3 удаа солигдсон байна.

### **Аудитын чанараас үр өгөөж бий болгоход анхаарах зүйлс**

Аудитын чанарын үр өгөөжийг мөнгөн дүнгээр тооцоход хэцүү, аудитын чанарын тодорхой санхүүгийн өгөөжийг тооцоолоход бэрхшээлтэй байдаг. Гэсэн хэдий ч аудитын чанарын үнэ цэнийг үнэлэх шууд бус дараах анхаарах зарим арга замуудыг дурдъя. Үүнд:

- **Залилангаас урьдчилан сэргийлэх зардлын хэмнэлт:** Аудитын чанарын өгөөжийг тооцоолох нэг арга бол залилангаас урьдчилан сэргийлэх зардлын хэмнэлтийг тооцоолох явдал юм. Чанартай аудит хийхээс өмнө болон дараа нь залилан мэхэлсэн үйлдлийг шалгаж, залруулахтай холбоотой зардлыг харьцуулах замаар үүнийг хийж болно. Залилан, үрэлгэн, урвуулан ашиглах тохиолдлыг бууруулснаар байгууллагууд өөрөөр алдаж байсан санхүүгийн эх үүсвэрээ хэмнэж чадна.
- **Үр ашгийн өсөлт:** Аудитын чанар нь байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Жишээлбэл, үйл ажиллагааны үр ашиггүй байдлыг тодорхойлох, үйл

явцыг оновчтой болгох эсвэл дотоод хяналтыг сайжруулах нь зардлыг хэмнэх эсвэл нөөцийг оновчтой болгоход хүргэдэг. Эдгээр хэмнэлтийг аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхээс өмнөх болон дараах зардлыг харьцуулах замаар тодорхойлж болно.

- **Шийдвэр гаргах, гүйцэтгэлийг сайжруулах:** Аудитын чанар нь шийдвэр гаргах болон байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад хүргэж болох үнэ цэнтэй ойлголт, зөвлөмжийг өгдөг. Санхүүгийн өгөөжийг эдгээр үр өгөөжтэй шууд хамааруулах нь хэцүү байж болох ч байгууллагууд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсний дараа орлогын өсөлт, зардлын бууралт, ашигт ажиллагааны өсөлт зэрэг гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг үнэлэх боломж бий болдог.
- **Оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх:** Аудитын чанараар олж авсан итгэл, итгэлцэл нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах, зээлийн зардлыг бууруулах зэрэг санхүүгийн шууд бус үр өгөөжийг авчирдаг. Эдгээр үр ашгийг аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхээс өмнө болон дараа нь хувьцааны үнэ, зээлжих зэрэглэл, хөрөнгийн өртөгт гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх замаар тооцоолж болно.

Аудитын чанарын тодорхой санхүүгийн өгөөжийг тооцоолоход янз бүрийн хүчин зүйлийг сайтар судалж, авч үзэх шаардлагатай гэдгийг анхаарах нь чухал юм. Дээр дурдсан шууд бус үр өгөөж нь аудитын чанарын санхүүгийн үр дүнд үзүүлэх нөлөөллийг үнэлэх эхлэлийн цэг болдог гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

Төрийн аудитын байгууллагуудын үр өгөөжийн бүртгэл нээлттэй бус байгаагаас Дорнод аймаг дахь ТАГ-ын тухайн аудитаас тооцсон үр өгөөжийг үнэлэх боломжгүй байна.

Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын 2021-2023 онд хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар дараах үр өгөөжүүдийг бүртгэж, тайлагнасан байна.

- 2021 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг, төсвийг урьдчилан хийгээгүй 43.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тусгаж, батлуулсан зөрчлийг таслан зогсоосон,
- 2021 онд улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардалд орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгаж, батлуулсан зөрчлийг таслан зогсоосон,

- 2022 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 566.0 сая төгрөгийн урсгал зардал, урсгал засварын шинж чанартай төсөл арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоов,
- 2022 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлснээр гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй 656.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан,
- 2022 онд хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй "Инженерийн шугам сүлжээ"-г хувийн хэвшлээс 633.6 сая төгрөгөөр худалдан авахаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан зөрчлийг таслан зогсоосон,
- Хүдэрийн сумаас Ерөө сум хүртэлх хатуу хучилттай 2,500.0 сая төгрөгийн өртөгтэй авто замыг бүртгэл, тайланд тусгуулсан.

Үр өгөөжийн бүртгэл, тайлагналаас харахад жил бүр тооцсон үр өгөөжийн дүн өссөн харагдаж байгаа боловч зарим үр өгөөжийн хэрэгжилт хангалтгүй байна.

### ДҮГНЭЛТ

Дээрхээс дүгнэхэд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хууль, эрх зүйн мэдлэг, чадвар сул, хүний нөөц нь тогтворгүй, мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаагүй зэрэг нөхцөл байдал нь аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр өгөөжийг бууруулж байна.

Иймд аудитын шийдвэрийн чанар, хэрэгжилтийг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд дараах хууль, журмуудад доорх өөрчлөлтийг оруулах талаар холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлэх шаардлагатай байна.

- Төсвийн тухай хуульд улс, аймаг, сумын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах хөрөнгө оруулалтын шинж чанар, төсөвт өртгийг ялгаатай тогтоож өгөх,
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тухай шатны Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчийн Хурал нь хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг өргөн мэдүүлсэн эсвэл Засаг даргын өргөн мэдүүлсэн төсөвт өөрчлөлт оруулж батлахдаа хууль бус шийдвэр гаргавал хариуцлага хүлээдэг байх, эсвэл хориглосон заалт оруулах,
- Төрийн аудитын байгууллага нь шат, шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төсөв батлах үед зөвлөх эрхтэй оролцохоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах.



- *Төрийн албан хаагчийг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг хангах, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хөтөлбөрт хамруулах.*

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Ном

1. Бурмаа.Н Төрийн хяналт хариуцлага, УБ, 2018
2. Энхбаатар.С, Төрийн аудит: Арга зүй, шинжилгээ, шинэчлэл УБ, 2019
3. Эрдэнэчулуун.Л, Хандлага-1 аудитуруудад зориулав, УБ, 2020
4. Орчуулагч, Бадамханд.Л, Бүнчинсүрэн.Д, Очирсүх.Я, Хатанболд.О, АДБОУС 10-40, 100-400

### Хууль, тогтоомж

1. Төрийн аудитын тухай хууль, 2003 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр, УБ
2. Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр УБ
3. Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001-2015 стандарт
4. МУЕА-ын 2023 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын чанарын хяналтын журам”

### Судалгааны тайлан, илтгэл

1. Батсайхан.Ж, Аудитын илрүүлэлтийг үнэлж, шийдлийг оновчтой гаргах УБ, 2023
2. Наранчимэг.Ц, Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан, үр дагавар УБ, 2023
3. Самбууням.Я, Аудитын шийдвэрийн нээлттэй ил тод байдлыг хангах ая холбогдол, үр нөлөө, УБ, 2023
4. Оюунгэрэл.С, Аудитын явцад өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, хариу арга хэмжээг оновчтой болгох нь, УБ, 2023
5. ҮАГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар, Аудитын чанарын хяналтын журмын хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа, УБ, 2022
6. ҮАГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлан
7. Дамдиндорж.Н, Аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлийн харьцуулсан судалгаа УБ, 2019